



БАТЛАВ:
БОАЖЯ-ны ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН,
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ГАЗРЫН ДАРГА

Ц.БАНЗРАГЧ



АММИ ХХК-ийн ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

А.МӨНХБАТ



БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР - 2009

ХЯНАСАН:
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН
НӨӨЦИЙН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

С.ЭРДЭНЭЦЭЦЭГ

АММИ ХХК-ийн БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖЕР

ГЛЕН АЙНСВОРТ

Ж.ОЮУСУВД

БОЛОВСРУУЛСАН: АММИ ХХК-ийн БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЭЛТЭС

ГАРЧИГ

ОРШИЛ	4
1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ЗОРИЛГО	5
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ БАЙГАЛЬ ОРЧНЫ СУУРЬ НӨХЦӨЛ	6
2.1 Газарзүй, геологи	6
2.2 Уур амьсгал	6
2.3 Ус	6
2.4 Хөрс	7
2.5 Ургамлын аймаг	7
2.6 Амьтны аймаг	7
3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН СИСТЕМ	8
4. ОЮУ ТОЛГОЙ ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	10
4.1. Геологи хайгуулын ажил	10
4.2. Далд уурхайн бэлтгэл ажил	11
5. БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	12
6. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	16
7. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	24
8. БАЙГАЛИЙН НӨӨЦ БАЯЛАГ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР	29

ОРШИЛ

АММИ ХХК Монгол улсын өмнөд говийн бүсэд орших Оюу Толгойн зэс-алтны ордын ашиглалтын 6709А лицензийг эзэмшдэг бөгөөд тус ордыг ил болон далд аргаар олборлох боломжтой юм.

Оюу Толгой төслийн үйл ажиллагаа нь ил болон далд уурхай, баяжуулах үйлдвэр, дэд бүтцийн байгууламжууд болон өндөр агуулгатай алт, зэсийн баяжмалыг хэрэглэгчдэд хүргэх гэсэн хэсгүүдээс бүрдэнэ. Одоогоор Оюу Толгой төсөл нь энэхүү томоохон хэмжээний ордыг ашиглах олон үе шат бүхий цогцолбор төлөвлөгөөний зөвхөн эхний шатыг буюу уурхай байгуулах бэлтгэл ажлыг гүйцэтгэхийн хажуугаар хайгуул судалгааны ажлыг үргэлжлүүлэн хийж байна.

АММИ компани нь Монгол улсын Засгийн газартай Оюу толгой төслийн Хөрөнгө оруулалтын гэрээг эцэслэн хийхээр ажиллаж байгаа бөгөөд үүнтэй холбогдуулан үйл ажиллагааныхаа цар хүрээг 2009 онд дахин бууруулан зөвхөн геологи хайгуулын ажил болон босоо ам 1-ийн 1300 м-ийн гүн дэх хөндлөн малталтын үйл ажиллагааг үргэлжлүүлэхээр төлөвлөөд байна.

АММИ ХХК нь ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд хуулиар хүлээсэн үүргийн дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн байгууллагаар дэс дараатай хийлгэж байгаа бөгөөд тус үнэлгээний тайлан дахь зөвлөмжийн дагуу байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг жил бүр төлөвлөн, батлуулж ирсэн.

Оюу Толгой төслийн Байгаль орчныг хамгаалах 2009 оны төлөвлөгөө, хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааг байгаль орчинд хохирол багатай явуулах, агаар мандал болон усны бохирдолт, хүн, амьтан, ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх цогц арга хэмжээ, хортой болон хор хөнөөл учруулж болзошгүй бодис, материалыг хадгалах, хяналт тавих менежментийн төлөвлөгөө, газрын гадаргуугийн болон гүний усыг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө ба бусад арга хэмжээг тусгаж өгөв.

Энэхүү тайлан нь оршилоос гадна 8 бүлэг, 6 хүснэгт бүхий нийт 30 хуудаснаас бүрдэнэ.

Байгаль орчны хэлтэс

1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ЗОРИЛГО

АММИ компанийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилго нь тус улсад явагдаж буй геологи хайгуулын үйл ажиллагааг олон улсын болон Монгол улсын байгаль орчны хуулиудын хүрээнд мөн компаниас баримталж буй байгаль орчны менежментийн үндсэн бодлогын дагуу явуулахад оршино.

АММИ ХХК нь байгаль орчныг хамгаалах талаарх бодлогыг дараах байдлаар тодорхойлсон:

- ✦ Байгаль орчны удирдлагын ISO 14000 олон улсын цуврал стандартуудад нийцсэн байгаль орчны менежментийн системийг нэвтрүүлэн, үйл ажиллагааг байнга хянаж сайжруулж байх нөхцөлөөр хангана;
- ✦ Бохирдлоос сэргийлэх, нөөц баялгийг үр ашигтай зарцуулах зорилгоор байгаль орчинд учрах нөлөөллийг тодорхойлж, үнэлж, бууруулж, зохицуулах арга хэмжээ авна;
- ✦ Байгаль орчны талаархи хууль тогтоомж болон бусад бүх шаардлагад нийцүүлэх;
- ✦ Хайгуул, бүтээн байгуулалт, ашиглалт, уурхай хаах зэрэг өөрийн бүх үйл ажиллагааны явцад байгаль орчинд тавих анхаарлаа орхигдуулахгүй;
- ✦ Байгаль орчны талаар хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэхэд нь туслах зорилгоор салбарын удирдлагуудад дэмжлэг үзүүлж, сургалт явуулна;
- ✦ Байгаль орчинд учруулсан нөлөөлөлд тогтмол үнэлэлт өгч, хяналт тавьж тайлагнана;
- ✦ Компанийн ажилтнууд, хувьцаа эзэмшигчид, нутгийн иргэдтэй байгаль орчны асуудлаар нээлттэй, шударга, ажил хэрэгч харилцаа хөгжүүлнэ;
- ✦ Нутгийн ард иргэдийн уламжлагдаж ирсэн эрх, соёлын өвийг хүндэтгэж хамгаална.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ СУУРЬ НӨХЦӨЛ

АММИ компанийн Оюу толгой төсөл нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Жавхлант багийн нутаг дэвсгэр дэх Оюу толгой гэдэг газарт нийтдээ 23,867 га газрыг хамарсан ашиглалтын 6709А лиценз бүхий талбайд явагдаж байна. Үүнд 2003 оны 12 сарын 23-д АММИ ХХК-д олгогдсон 6708А – Манахт, 6709А – Оюу Толгой, 6710А – Хөх Хад, 6711А – Улаан Уул зэрэг тусгай зөвшөөрлүүд бүхий талбайнууд орно.

2.1 Газарзүй, геологи

Оюу толгой орд нь газар зүйн хувьд Галбын говийн нутаг дэвсгэрт хамаарна. Галбын говь манай орны хамгийн нам дор оршдог говь, цөлийн тэгш талархаг нутаг юм. Ерөнхий өндөршил нь далайн түвшнээс дээш нь 937.3м (Булан Сухай) - 1202.3м (Загалын Хүрэн Овоо) хооронд хэлбэлзэнэ.

Тус нутгийн геологийн тогтоц нилээд нийлмэл бөгөөд суурь хурдас нь цэрдийн настай конгломерат, элсэн чулуу, алевролит, неогенийн настай шавар бөгөөд тектоникийн хэрчигдэлд их орсон нилээд нийлмэл тогтоцтой юм. Харин замын суурь болдог дөрөвдөгч, орчин үеийн хурдасны хувьд нилээд зузаан бөгөөд 20-180 м хүртэл зузаантай элс, хайрга, шавар үелэн тогтсон байдаг.

2.2 Уур амьсгал

Уур амьсгалын хувьд тус нутагт эх газрын эрс тэс уур амьсгал давамгайлдаг. Хавар намартаа сэрүүн, зундаа халуун, өвөл нь хүйтэн. Хавар нь хуурай салхитай, үе үе хүчтэй шуурдаг. Говийн эрс тэс уур амьсгал төслийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн нөхцөлд хүчтэй нөлөөлөх хүчин зүйл болж байна. Температурын хэлбэлзэл маш их буюу өвөлдөө доод тал нь -31°C , зундаа 40°C –аас давж гарах нь элбэг.

Оюу Толгой орчмын нутаг дэвсгэр хүн ам цөөтэй, үйлдвэрлэл дэд бүтэц сул хөгжсөн, хүрээлэн буй орчны агаарт нөлөөлөх хог хаягдлийн болон бохирдуулагч эх үүсвэр байхгүй нутаг дэвсгэрт оршдог. Улирлын шинж чанартай шороон шуургыг л тооцохгүй бол энэ нутаг нь үндсэндээ цэвэр цэнгэг агаартай юм.

2.3 Ус

Түр зуурын урсгалтай голууд нь хур борооны үеэр түр урсаад хэд хоногийн дараа хатаж, ширгэдэг. Зуны хүчтэй салхи шуургатай борооны дараа хуурай сайр, гольдролуудын дагуу богино хугацаанд маш хүчтэй хуйларсан урсгал үүсгэх (уруй) ба үүнийг говийн “догшин” үер гэж нэрлэдэг.

Төсөл хэрэгжүүлж буй Оюу Толгойн лицензийн талбайн баруун болон баруун урд талаар тухайн нутгийн экологид чухал ач холбогдол бүхий Ундайн голын хуурай сайр дайран өнгөрдөг бөгөөд уг голын гольдролын хөрсний дээд хэсэгт гүний суурь чулуулаг хөрсөнд ойртсон хэсгээс ундрэн гарах задгай булаг шанд хэд хэд бий. Эдгээрээс хамгийн том нь хайгуулын анги одоогоор байрлаж буй газрын баруун өмнө талд байх Бор Овооны булаг юм. Ийм горхиууд өвөл хөлдөж мөс нь голын эргээс хагас метр хүртэл илүү гарах үе бий. Эдгээр цэвэр ус бүхий горхи булгууд нь зэрлэг

ан амьтан, мал, мөн зуны саруудад элбэг тааралдах Монгол бахын амьдралыг тэтгэж байдаг.

Өрөмдлөгийн ажлын үр дүнд илрүүлсэн ул хөрсний ус хүртэлх гүний хэмжээ төслийн нутаг дэвсгэрт янз бүр байна. Энэ хэмжээ Ундайн голын гольдролын дагуу гадаргаас 3 м хүрэхгүй байхад Өмнөд болон Төв ордуудад 65 м хүрч байна.

2.4 Хөрс

Говийн бүсийн хөрс ургамлан бүлгэмдлээр нэн ядмаг учраас элэгдэл эвдрэлд орох нь хялбархан байдаг онцлогтой. Оюу Толгой орчмын нутаг нь хөрс газарзүйн мужлалтаар хөрс био-уур амьсгалын өргөргийн бүсчлэл бүхий Говийн мужийн Цөлийн бор саарал хөрс бүхий 12-р тойрогт багтдаг.

Хөрсний хээрийн судалгаагаар говийн хөрсний төрөлд хамаарах 3 дэд төрлийн хөрсийг тэмдэглэсэн. Үүнд:

1. Цөлийн цайвар бор
2. Цөлөрхөг хээрийн цайвар бор
3. Цөлөрхөг хээрийн саарал бор хөрс орно.

2.5 Ургамлын аймаг

Оюу Толгой орчмын ургамал нь Төв Азийн цөл болон цөлөрхөг хээрийн ургамлын аймгийн төрөлд багтана. Цөлийн өргөн уудам тэгш тал ба нам толгод нь ган гачигт тэсвэртэй жижиг бут, сөөгөөр (<0.5 м) армаг тармаг бүрхэгдсэн. Түр зуурын урсгалтай голын гольдролууд, хуурай жалгууд болон шал хөрс нь зарим зүйлийн мод ургах нөхцлийг бүрдүүлэх бөгөөд, бутнууд нь гүний ус ойрхон байдаг газруудад голчлон ургана.

Лицензийн талбай дахь дээд цоргот ургамлын зүйлийн бүрэлдэхүүний жагсаалтыг 2002 онд анхлан гаргасан бөгөөд 2008 оны байдлаар 33 овгийн, 99 төрлийн, 154 зүйл ургамал ургаж байна гэж шинэчлэн бүртгээд байна.

2.6 Амьтны аймаг

Оюу Толгойн нутаг дэвсгэрийн амьтны аймгийг 2002, 2003 онуудад судалж нийт 298 зүйл байгааг тэмдгэлсэн. Үүнээс:

- | | |
|-----------------|-----|
| ✓ Хөхтөн | 43 |
| ✓ Шувууд | 62 |
| ✓ Хоёр нутагтан | 1 |
| ✓ Мөлхөгчид | 10 |
| ✓ Шавьж | 183 |

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН СИСТЕМ

Оюу Толгой төслийн олон талын үйл ажиллагаанд зориулсан Байгаль Орчны Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй байгаль орчны суурь судалгаа, үнэлгээг хийж дуусгасан. Эдгээр төлөвлөгөөний боловсруулалт, хэрэгжилт нь БОНБҮ-ий хэрэгжилттэй нийцэж байдаг. Оюу Толгой төслийн Байгаль Орчны менежментийн төлөвлөгөөний одоогийн нөхцөл байдлыг 1-р хүснэгтээр харууллаа.

Оюу Толгой төслийн үйл ажиллагаанд авагдаж байгаа бүх урьдчилсан арга хэмжээ нь тухайлбал БОНБҮ-ний материалууд, Байгаль Орчинг Хамгаалах Төлөвлөгөө (БОХТ), Байгаль Орчны Хяналт Шинжилгээний Хөтөлбөр (БОХШХ) зэрэг нь уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнөх болон үйл ажиллагааны үеийн барилгажилтын төслийн зураг дизайныг хамарсан байгаа. АММИ-ийн Байгаль Орчны хэлтэс одоогоор байгаль орчны үйл ажиллагаа, түүний хэтийн төлөвийг Монгол улсын байгаль орчны холбогдох хууль тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэж байна. БОНБҮ нь төслийн байгаль орчны менежментийн системийг хөгжүүлэх үндэс суурь нь болж өгдөг.

АММИ нь Байгаль орчны менежментийн хамгийн сайн туршлагыг нэвтрүүлэх, олон улсын түвшинд үйл ажиллагаагаараа танигдсан албан ёсны сертификатыг олж авахын төлөө ажиллаж байна. Тиймээс АММИ ISO 14001-ийн шаардлагууд болон тэдгээрийн зорилтыг агуулсан Байгаль Орчны Менежментийн системийг (БОМС) амжилттай хэрэгжүүлж эхэлсэн.

Барилгажилтын явцад БОМ-ийн системийн хэрэгжилт нь эхэндээ байгаль орчны бодлого, байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл, хуулийн заалт, зорилго, зорилт болон байгаль орчны хөтөлбөр гэх мэт түлхүүр буюу үндсэн санаанууд дээр төвлөрөн ажилласан. Мөн Байгаль орчны зөрчлийг мэдээллэх гэх мэт үндсэн журмууд ч бас шат дараалан хэрэгжиж байна. Аудит болон менежментийг дахин хянаж шалгаж үзэх үйл явцууд системийн үндсэн суурь нь нэгэнт үүсэн бий болсны дараа хэрэгжиж эхлэхээр тусгагдсан болно.

Хүснэгт 1. Байгаль орчны удирдлагын тогтолцооны төлөвлөгөө

Төлөвлөгөө	Зорилго	Статус
Барилгын гэрээт компаний Эрүүл ахуй, Хөдөлмөр хамгаалал, Байгаль орчны менежмент	Байгаль орчны болон соёлын өвийг хамгаалах, барилгажилтын үеэр хөрс, ургамал, амьтанд сөргөөр нөлөөлөхөөс сэргийлэх	Барилгын төслийн баг барилгажилтын үеийн хүмүүсийн эрүүл ахуй хөдөлмөр хамгаалалтын төлөвлөгөөг сайжруулж биелүүлж ирсэн.
Хайгуулын үеийн байгаль орчны менежмент	Эрдэс баялаг, усны хайгуулын үйл ажиллагаанд стандарт туршлагыг хэрэгжүүлснээр байгаль орчны болон соёлын өвд учрах эвдрэл гэмтэл багасана.	АММИ-ийн усны болон хайгуулын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.
Хаягдлын (уурхайн бус) менежмент	ОТ анги, засварын газар мөн тэсрэх бодисын үйлдвэрүүдээс гарч байгаа шингэн, хатуу, хортой, хоргүй материалын устгал тэдгээрийн тээвэрлэлтийн менежмент	Барилгажилтын үед зориулсан урьдчилсан төлөвлөгөөг боловсруулан гүйцэтгэсэн.
Уурхайн хаягдлын менежмент	Тоосжилтоос сэргийлэх мөн газрын доорхи болон гадаргуугын усыг хамгаалах зорилготой далан хийх,	Ашиглалт эхлэхээс өмнө гүйцэтгэх
Агаарын чанарын менежмент	Ажилчдын эрүүл мэндийг хамгаалах үүднээс орчны агаарын чанарын стандартыг хэрэгжүүлснээр агаарын бохирдлыг бууруулах агаарын эх сурвалжын менежмент	Ашиглалт эхлэхээс өмнө гүйцэтгэх
Усны менежмент	Усны нөөцийн болон чанарын менежмент нь гадаргын усны чигийн өөрчлөлт, газрын доорхи ус зэрэг сэдвүүдийг багтаана.	Ашиглалт эхлэхээс өмнө гүйцэтгэх
Hazardous Materials and Hydrocarbons Management Plan	Усны болон хөрсний нөөцийг хамгаалахад чиглэсэн нүүрс ус болон хортой химийн материалын тээвэрлэлт хамгаалалтын менежмент	Ашиглалт эхлэхээс өмнө гүйцэтгэх
Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	Уурхайн болон түүний үйл ажиллагаанд зориулсан хаалтын болон нөхөн сэргээлтийн стандартад шалгуур тогтоох	Уурхайн хаалтын болон нөхөн сэргээлтэд зориулсан урьдчилсан төлөвлөгөө дууссан.
Ургамлын менежмент	Жагсаалтад орсон ургамлыг хамгаалах, ургамлыг гэмтээх болон устгалыг багасгах, нөлөөлөлд өртөх боломжтой талбайн ургамлыг хамгаалах	Барилгажилтын үед гүйцэтгэх урьдчилсан гарын авлага боловсруулах.
Түүх соёл, Археологийн дурсгалт зүйлийн менежмент	Түүх соёлын дурсгалт зүйл бүхий талбайг хамгаалах, ялангуяа барилга болон уурхайн үйл ажиллагааны явцад шинээр олдвор олдвол холбогдох газар нь мэдэгдэх тэмдэглэж авах журмыг боловсруулах	Барилгажилтын үед гүйцэтгэх урьдчилсан гарын авлага боловсруулах.

Хүснэгт 2. 2008 оны 1-р сарын байдлаар гүйцэтгэсэн байгаль орчны менежментийн систем

Procedures	Заавар	Төлөвлөгөө
<ul style="list-style-type: none"> • Байгаль орчны удирдлагын тогтолцооны гарын авлага • Засан сайжруулах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ • Бичиг баримтын хяналт • Бүртгэлийн менежмент • Хаягдлын менежмент • Асгаралтын үед авах арга хэмжээ • Тоосны мониторинг • Хаягдал усны менежмент 	<ul style="list-style-type: none"> • Байгаль орчны бодлого • Байгаль орны удирдлагын хяналтын заавар • Нүүрсустөрөгч, аюултай, хортой бодис • Аюултай, хортой бодисын хадгалалт, тээвэрлэлт • Барилгын ажлын явц дахь тоосны хяналт • Бохир ус цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа • Газрын элэгдэл эвдрэл • Археологи палентологийн олдвор 	<ul style="list-style-type: none"> • Хаягдлын менежмент • Гэрээт компаний Эрүүл ахуй, Хөдөлмөр хамгаалал, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гарын авлага • Хайгуулын үеийн байгаль орчны менежмент • Гэрээлэгч – Байгаль орчны менежмент

АММИ-д дэлхийд томд тооцогдох нөөцийг олборлож ашиглах, үүний тулд БОМ-ийн төлөвлөгөөг биелүүлэх, боловсронгуй болгох таатай боломж тохиосон. Энэхүү төлөвлөгөөний хэрэгжилт нь БОМС-ээр төслийн үйл ажиллагааг чанартай болгох, мөн АММИ-ийн БОМ-ийн хамгийн сайн туршлагыг хэрэгжүүлэх үүрэгтэй болгоход чиглэнэ.

4. ОЮУ ТОЛГОЙ ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1. Геологи хайгуулын ажил

2009 оны хайгуулийн ажлын урьдчилсан төлөвлөгөөгөөр лицензийн талбайн өмнөд хэсэгт 2 ширхэг өрмийн суурь машинаар өрөмдлөгийн ажил үргэлжлэнэ. Эдгээр алмазан өрөмдлөгийн машин нь давхар яндантай, өрөмдлөгийн яндангийнхаа цувааг сугалахгүйгээр кернээ авдаг технологитой, 103.2 мм (PQ), 77.8 мм (HQ), 60.3 (BQ) мм-ийн диаметр бүхий керн гаргадаг өрмийн машинууд юм.

2009 онд хийх өрөмдлөгийн ажлыг Межер Дриллинг компани дангаар хийж гүйцэтгэх бөгөөд тус компани нь Оюу Толгой дахь засварын цехэд буюу зориулалтын талбайд өрмийн суурь машинуудын засвар үйлчилгээг хийдэг. Үйлчилгээ хийхэд ялгарах хаягдал тосыг түр хадгалах 25 тн багтаамжтай савыг уг талбайдаа байршуулсан байна.

Болзошгүй сөрөг нөлөөлөл

Газрын хэвлий, хөрс ургамлан бүхэвч, гадаргын болон газрын доорхи ус, агаарын чанар эзрэгт сөргөөр нөлөөлж болзошгүй. Геологи хайгуулын ажлын үед байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллүүдийг Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө бүлэгт дэлгэрэнгүй авч үзсэн бөгөөд гол сөрөг нөлөөллөөс дурьдвал:

- өрмийн зумпны нүх ухах,
- өрмийн зумпний шингэнд ус ашиглах, зууралдуулагч бодисын уусмал бэлтгэх
- зумпны шингэн нүхнээс хальж асгарах

- зумпны нүхэнд мал, амьтан унаж осолдох
- цооногийн талбайд хөрс хуулах, ургамлын бүрхэвчийг устгах
- цооногийн талбайд хог хаягдал хийсэх, шатах тослох материал асгарч хөрсийг бохирдуулах
- газрын доорхи уст үеүд холилдох
- өрмийн цооногууд хооронд шинээр зам гарах гэх мэт.

Бууруулах арга хэмжээ

- ✓ Зумпны нүхийг шинээр ухах үедээ гарсан шороогоор далан хийж манах, нэмэлт хашлага саад хийж, хараа хяналтгүй мал амьтан ойртож, унаж осолдохоос сэргийлэх
- ✓ Зумпны шингэнд холих бодист олон улсын стандарт ангиллаар аюулгүй гэж үнэлсэн, бичил организмын нөлөөгөөр өөрөө задрах чадвартай бодисыг ашиглах
- ✓ Зумпны шингэнд ашиглах усыг аль болох дахин ашиглах, цэвэршүүлсэн усыг ашиглах зэргээр усны нөөцийг хомсдохоос сэргийлэх
- ✓ Малчдын гар худгийн уснаас ямар ч тохиолдолд ус авч ашиглахгүй байх
- ✓ Өрмийн суурь машин нүүх үед зумпны нүхийг нэн даруй булж тэгшлэх, холбогдох стандартын дагуу нөхөн сэргээлтийг хийж үлдээх
- ✓ Цооногийн талбайд өрмийн суурь машинд засвар үйлчилгээг хийхээс аль болох зайлсхийх, гарцаагүй хийх болсон тохиолдолд асгаралтаас сэргийлэх тосгуур, шингээгч материалуудыг бэлэн байлгах
- ✓ Өрмийн суурь машинуудын моторын дор зориулалтын тосгуур байрлуулан техникийн тос, хаягдал шингэн хөрсөнд асгарахаас сэргийлэх
- ✓ Хаягдал тосыг түр хадгалах саванд юүлэх үед гадуур нь асгарахаас сэргийлэх, шатах тослох материалын асгаралт болсон тохиолдолд тухайн ээлжийн ахлах ажилтнаар дамжуулан БО хэлтэст яаралтай мэдэгдэж байх, асгаралтын үед мөрдөж ажиллах журмыг дагаж мөрдөх
- ✓ Өрмийн цооногийн талбайд үүсэн гарч буй хог хаягдлыг ангилан ялгаж, зохих журмын дагуу байгаль орчинд халгүйгээр устгалд оруулах, шаардлага хангасан хогийн савуудыг байршуулж, хогийг тээвэрлэн хаях үйл ажиллагааг тогтмолжуулах
- ✓ Цооног хооронд явах гол ашиглагддаг замуудыг сайжруулан, усалгааг тогтмолжуулах, шинээр зам үүсгэхгүй байхад анхаарах

4.2. Далд уурхайн бэлтгэл ажил

Оюу Толгой ордын Хойд Хюго хэсгийн газрын гүнд хийх нарийвчилсан хайгуулын ажил, ирээдүйн далд уурхайн ам байгуулах бэлтгэл ажлын хүрээнд Босоо ам 1, ба Босоо ам 2-ыг байгуулах ажлыг урьд жилүүдэд эхлүүлсэн. Гэвч хөрөнгө оруулалтын гэрээний байдлаас шалтгаалан Оюу Толгой төслийн үйл ажиллагааны цар хүрээг багасгасан горимоор ажиллуулж байгаа бөгөөд одоогоор зөвхөн Босоо ам 1-ийн 1300 м-ийн түвшингээс хоёр тийш хойд болон зүүн зүгт чиглэсэн хөндлөн малталтуудыг үргэлжлүүлэхээр төлөвлөж байна.

Ашигт малтмалын хуулийн дагуу Хойд Хюго ордын нарийвчилсан хайгуул хийх босоо нэвтрэлийн уулын ажлын 2008 оны төлөвлөгөөг боловсруулан холбогдох мэргэжлийн байгууллагаар батлуулж ажиллана.

5. БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

АММИ компани нь 2002 оны 7-р сараас Оюу Толгой Төслийн Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын Нарийвчилсан Үнэлгээний (БОНБҮ) ажлуудыг төслийн талбайд эхлүүлсэн юм.

Оюу Толгой төслийн хүрээнд шат дараалалтайгаар хийгдэж буй нарийвчилсан үнэлгээний тайлангууд нь Байгаль Орчны Яамнаас гаргасан ерөнхий үнэлгээний дагуу бэлтгэгдэж, хүргэгддэг бөгөөд заасан цаг хугацаанд дараах зүйлүүд зайлшгүй хийгдсэн байх ёстой:

- Үнэлгээний ажлуудыг бүрэн дүүрэн хийж дуусгасан
- Хангалттай зурган мэдээ мэдээлэлийг оруулж өгсөн байх
- Байгаль Орчны Яамаар хянуулж, баталгаажуулах боломжтой болсон байх

Эдгээр шаардлагуудын дагуу бэлтгэгдэж буй нарийвчилсан үнэлгээний тайлангуудын нэгтгэлийг 3-р хүснэгтээр үзүүлэв.

Боть I

Оюу Толгойгоос Гашуун Сухайтын хилийн боомт хүртэл тавигдах хатуу хучилттай замын БОНБНҮ-ий тайланг 2004 онд БОЯ-аар баталгаажуулсан. Гашуун Сухайтын хилийн боомт хүртэлх замын трасс өөрчлөгдсөний улмаас нарийвчилсан үнэлгээний тайланд зарим засвар, нэмэлт өөрчлөлтүүд оруулсан нэмэлт тодотгол тайланг 2007 хийж, мөн ондоо батлагдсан.

Боть II

Гүний Хоолойн Усны Нөөц:

II-р ботгийн БОНБНҮ-ий тайлан 2006 онд батлагдсанаас хойш уурхайн болон үйлдвэрлэлийн төлөвлөгөө, зураглал дизайныг сайжруулснаар бүтээгдэхүүний хэмжээ ихээр нэмэгдэж өдөрт 85,000 тон хүдэр гаргахаар төлөвлөж байснаас 110,000 тонн/өдөр-ыг үйлдвэрлэхээр болсон байна.

Мөн 2002 онд явуулсан Гүний хоолойн гидрологийн томоохон хэмжээний судалгаа нь цаашдын уст үеийн хүчин чадал, онцлог, ашиглах боломжтой нөөцийн хэмжээг тодорхойлж өгсөн. Акватерра компани энэхүү усны нөөцийн судалгааг хийж, Гүний хоолой дахь усны нөөцийг 1122 л/сек хэмээн тодорхойлжээ.

АММИ-ийн усны мэргэжилтнүүдийн хийсэн “Гүний усны хайгуулын тайланг” (2007) БОЯ-нд 2008 оны 1 сард өргөн барисан бөгөөд Усны Салбарын Шинжлэх Ухаан Технологийн Зөвлөл хянаж, нарийвчлан тооцоолсны үндсэн дээр 870 л/сек усны нөөцийг баталж цаашид хийгдэх хяналт шинжилгээний хөтөлбөр, шалгалтыг шаардаж байна. Усны нөөцийг баталсан албан ёсны бичиг баримтуудыг 2009 оны 1-р сард хүлээн авсан.

Төслийн хэрэгцээнд шаардлагатай усан хангамжийг баталгаажуулахын тулд хийх дараагийн арга хэмжээ нь ус ашиглах гэрээ болно.

Нэмэлт Тодотгол (Боть II)

Оюу Толгойн Усан Хангамжийн шугам хоолой, цооногуудын дэд бүтэц:

2-р ботьд хийгдсэн БОНБНУ нь орон нутгийн гүний усны түвшингийн бууралтад нөлөөлөх боломжит нөлөөллийг авч үзснээс биш, боловсронгуй болж буй усан хангамжийн шугамын дагуух дэд бүтцэд нөлөөлөх нөлөөллийг тусгаж өгөөгүй байна. 2007 онд БОЯ-аас гаргасан ерөнхий үнэлгээний зааварт Гүний Хоолойгоос Оюу Толгой руу татах усан хангамжийн дэд бүтцэд (цооног, шахуурга, шугам хоолой, ойр орчмын зам, хүчдэл дамжуулагчид, усан сан гэх мэт) БОНБНУ-ий нэмэлт тодотгол хийхийг шаардсан байна. Уг зааврын дагууд тодотгол үнэлгээний тайланг 2008 оны 12-р сар гэхэд БОЯ-д өгсөн байх ёстой боловч хөрөнгө оруулалтын гэрээнээс шалтгаалан 2009 оны 12-р сар хүртэл хойшлуулагдаад байна.

Боть III

3-р ботид хийгдсэн БОНБНУ-ий тайлан нь зэс алт олборлох, боловсруулах төслийн үйл ажиллагааг ил уурхайгаас авахуулаад бүх тоног төхөөрөмж, дэд бүтцийн тухайлбал баяжуулах үйлдвэр, хаягдлын агуулах зэрэг лицензийн талбайд байрлах обектуудыг бүгдийг хамарсан байдаг. Үнэлгээний ажил нь 2005 оны орд ашиглалтын цогцолбор төлөвлөгөөнд үндэслэн хийгдсэн ба 2006 оны ерөнхий төлөвлөгөөнүүдийг мөн тусгасан.

Зэс алт олборлох, боловсруулах төслийн үйл ажиллагааны БОНБНУТ нь далд уурхайн ашиглалтын байгаль орчныг хамгаалах шаардлагуудыг хамарсан тул цаашид байгаль орчны зөвшөөрөл, эсвэл яаманд хянуулахаар өгөх зэрэг нь шаардлагагүй болсон (2008 оны 11-р сар).

Боть IV

Нүүрсэн Галлагаатай Цахилгаан Станцын (3х150 мегаватын хүчин чадалтай) БОНБНУ-ий тайлан нь бэлэн болсон хэдий ч төслийн талбай дотор станцыг нүүлгэн шилжүүлэх бөгөөд үүнд хийх нэмэлт өөрчлөлтийг мөн тусгаж өгөх шаардлагатай. Энэ тайлангийн яаманд хүргүүлж шалгагдах эсэх нь яамнаас хийгдэх ерөнхий үнэлгээ болон АММИ Засгийн Газартай хийх хөрөнгө оруулалтын гэрээний үр дүнгээс шууд хамаарч байна.

Боть V

Нисэх онгоцны буудлыг Оюу Толгойн лицензийн талбайгаас хойш 10 км зайд нүүлгэн шилжүүлэхээр төлөвлөсөн. Энэхүү төслийн хүрээнд Фоккер 50 мөн Lockheed C130 нисэх онгоцонд тохирсон 2000 м хөөрөх буух зурвас, ирэх/явах зорчигчдыг онгоцонд хүргэх/авах машины зам, аюулгүйн зурвас, фартук, хяналтын цамхаг, зорчигчдийг тосч авах машины зогсоол, 15 х 15 м- хэмжээтэй хүлээх танхим, зурвас замын гэрэлтүүлэг, 40 киловолт амперийн хүчин чадалтай цахилгаан үүсгүүрээс нисэх буудлын цахилгаан эрчим хүчийг хангах мөн хөрсний ус зайлуулах систем болон буудлыг тойруулж хашаа зэргийг барих болно.

Боть VI

БОНБНУ-ий нэмэлт тодотгол тайлангуудыг дуусгаснаар хүдрийн нөөцийн бүртгэл болон 3-р боть болох зэс алт олборлох төслийн БОНБНУ-ээр батлагдсан Оюу Толгой төслийн ажил эхлэх боломжтой болж байгаа юм.

Тодотгол тайлан дараах төслүүдэд хийгдсэн болно:

- Босоо ам 1; 2
- Бетон зуурмагийн чулуулаг олборлох үйлдвэр
- Бохир ус цэвэршүүлэх байгууламж
- Дизель станц
- Дизелийн түлш хадгалах агуулах
- Тэсрэх бодисын үйлдвэр
- Химийн бодисын импорт, ашиглалт

БОАЖЯ-нд өргөн барихад бэлэн болоод байгаа тайлангуудыг дурьдвал:

1. Гүний Хоолойн усан хангамжийн шугам хоолойн төслийн БОНБНУ-ийн тайлан **Боть II**
2. Гүний хоолой Галбын говийн усны нөөцийн ашиглалтын БОНБНУ-ийн батлагдсан тайланд тодотгол хийлгэх талаар **зөвлөмж авах**
3. **Нүүрсэн галлагаатай цахилгаан станц Боть IV** – Байгаль Орчны ямаар ерөнхий үнэлгээ хийлгэх
4. Нүүрсэн галлагаатай цахилгаан станцын БОНБНУ-ий тайлан **Боть IV**

Хүснэгт 3. ОТ төслийн хүрээнд хийгдсэн БОНБНУ-ий ажлуудын нэгдсэн жагсаалт

БОНБНУ-ий бүрэлдэхүүн	Батлагдсан огноо	Статус	Нэмэлт, тодотгол үнэлгээ	Батлагдсан огноо	Статус
Боть I			Боть I		
ОТ-Гашуун Сухайтын дэд бүтцийн зурвасын БОНБНУ	2004	Замын трасс өөрчлөгдсөн	ОТ-Гашуун Сухайтын замын зурвасын БОНБНУ-ий тайланд оруулах нэмэлт, тодотгол	2007	батлагдсан
Боть II			Боть II		
Галбын Говь, Гүний Хоолой дахь газрын доорхи усны нөөцийг Оюу Толгойд ашиглах төслийн БОНБНУТ Гүний усны нөөц (GH - 210 л/сек)	2005	батлагдсан	Ус ашиглалтын хэмжээ нэмэгдсэн (GH - 870 л/сек) (тайлбар бичиг бэлтгэгдсэн)	2009	БОАЖЯ-нд өргөн барихад бэлэн болсон
Оюу Толгойн усан хангамжийн шугам хоолойн БОНБНУТ	Бэлэн болсон	БОАЖЯ-нд өргөн барих хугацааг 2009 оны 12.31 хиртэл сунгасан	-		
Боть III			Боть III		
Оюу Толгойн ордоос зэс, алт олборлох, боловсруулах төслийн БОНБНУТ	2007	Нэмэлт хийх шаардлагатай (2009 оны 2.13 7/458 тоотгоор)	-		
Боть IV			Боть IV		
Нүүрсэн галлагаатай цахилгаан станцын БОНБНУТ		БОАЖЯ-аар Ерөнхий үнэлгээ хийлгэх	-		
Боть V			Боть V		
Орон нутгийн онгоц буудлыг нүүлгэн шилжүүлэх төслийн БОНБНУТ	2007	батлагдсан	-		
Боть VI			Боть VI		
Дэд бүтэц –нэмэлт, тодотгол үнэлгээний тайлан			“Петровис” ХХК-ий Оюу Толгой орд газрын шатахуун түгээх станцад хийсэн БОНБНУТ	2004	батлагдсан
			Эмульсын задгай тэсрэх бодисын үйлдвэр байгуулах төслийн БОНБНУТ	2005	батлагдсан
			Оюу Толгой Хюго хэсэгт нэвтрэх 1-р босоо нэвтрэлтийн БОНБ-ын нэмэлт, тодотгол үнэлгээний тайлан	2005	батлагдсан
			Хюго хэсэгт нэвтрэх 2-р босоо нэвтрэлтийн БОНБ-ын нэмэлт, тодотгол үнэлгээний тайлан	2007	батлагдсан
			ОТ Ордоос бетон зуурмагийн чулуулаг олборлох төслийн БОНБНУТ	2007	батлагдсан
			Оюу Толгойд баригдах дизель станцын БОНБНУТ	2007	батлагдсан
			Бохир ус цэвэрлэх байгууламжийн БОНБНУТ	2007	батлагдсан
			Барилга, байгуулалтын үед ашиглагдах химийн бодисуудын БОНБ-ын болон эрсдлийн үнэлгээ	2008	батлагдсан

6. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь Оюу Толгой төслийн хүрээнд батлагдсан “Галбын говь, Гүний Хоолой дахь усны нөөцийг Оюу Толгойд ашиглах” БОНБНҮ-ий тайлан (Vol II), “Оюу толгойн ордоос зэс, алт олборлох, боловсруулах үйлдвэр”-ийн БОНБНҮ-ий тайлан (Vol III) болон бусад тодотгол тайлангуудын байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүд, тэдгээртэй нийцүүлэн боловсруулсан АММИ ХХК-ын дотоод журмуудад заасан байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн хураангуй, нэгтгэл болно (хүснэгт 2).

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа 2009 онд төлөвлөсөн Оюу Толгой төслийн үйл ажиллагаанууд, тэдгээрийн зүгээс байгаль орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй хүчин зүйлүүдийг тодотгож, урьд өмнө нь батлагдсан нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тохирох заалт, заавар зөвлөмж буюу нөлөөллийг бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг дэлгэрүүлж бичив.

Оюу Толгой төслийн 2009 оны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулах үед хийхээр төлөвлөөгүй аливаа ажил, үйл ажиллагааг тухайн онд төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр болсон тохиолдол бүрт байгаль орчныг хамгаалах нэмэлт төлөвлөгөөг боловсруулан холбогдох мэргэжлийн байгууллагаар батлуулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах болно.

Хүснэгт 4. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Байгаль орчны бүрдэл хэсэг	Үйл ажиллагаа	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	Босоо малталт	Хаягдал чулуулгийн овоолгоос үүсэх тоос	<p>Шаардлагатай тохиолдолд овоолгыг санхинд хийсч орчныг тоосоор дарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хайрга, чулуулгаар дарж өнгөлөх</p> <p>Цэвэр усны зумфэнд тунаж цэвэршүүлсэн усыг орчны тоосжилтыг бууруулах зорилгоор ажлын талбай болон чулуулгийн овоолго зэрэгт усалгаа хийх</p>	Shaft 1, 2 БОНБНУ Shaft 1, 2 БОНБНУ
Агаарын чанар	Бохир ус цэвэрлэх байгууламж	БУЦБ-ийн шүүр, хатуу хог хаягдлыг ялгах хэсэг, анхдагч болон хоёрдогч цэвэрлэгээний хэсэг, лаг боловсруулах хэсгээс гарч болох агаар бохирдуулах эвгүй үнэр.	Эвгүй үнэрийг багасгахын тулд лаг, хатуу хаягдлыг битүү саванд тэвэрлэж, хаягдлын цэгт хаяж хөрсөөр хучих	БУЦБ-ын БОНБНУ
	Ангилд болон ажлын байрны орчимд	Үнэрээс гадна идэвхжүүлсэн лагийг боловсруулах явцад метан (CH ₄), аммиак (NH ₃), хүхэрт устөрөгч (H ₂ S), диметилсульфид (C ₂ H ₆ S) болон меркаптан зэрэг агаар бохирдуулагч хийнүүд ялгарч болзошгүй	Агааржуулалтын системийг шалгаж бүрэн бүтэн байдлыг хангах, ослын үед авах арга хэмжээг тодорхойлох, хэрэгжүүлэх	БУЦБ-ын БОНБНУ
		Хүнд машин механизм, машины хөдөлгөөнөөс		Ариун цэврийн өрөөнүүдийн засвар, үйлчилгээг тогтмол хийх
Машин, техник		Тоосжилтыг бууруулах зорилгоор байгаль орчинд хортой бус зарим төрлийн химийн бодис ашиглах- dust suppressant materials (CaCl ₂ , MgCl ₂)	Цэвэрлэсэн усыг орчны тоосжилтыг бууруулах зорилгоор замын дагуу усалгаа хийх, машины хурдыг хянаж байх	БОНБНУ. Ш боть
			Үйл ажиллагааг эхлүүлэх болон хэрэгжүүлэх үедээ БО-ны хэлтсээс хяналттай ажиллах	БОНБНУ. Ш боть

Байгаль орчны бүрдэл хэсэг	Үйл ажиллагаа	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хөрс		Аливаа үйл ажиллагаануудыг эхлүүлэхээс өмнө өнгөн хөрсийг хуулан авч, тусгайлан зассан овоолго байдлаар хадгалах	Өнгөн хөрсийг хуулах, хадгалах менежментийг боловсруулах, олон улсын хэмжээнд хэрэгжүүлж байгаа уурхайн гэргүүн туршлагыг авч хэрэглэх	БОНБНУ. III боть
		Өнгөн хөрсний овоолгыг буруу хийснээс болж шимт байдал нь алдагдах	Өнгөн хөрсний овоолгуудыг стандартын дагуу хийх, салхинд алдагдахаас сэргийлэх зорилгоор хучилт хийх	
		Ажлын байрууд болон зам дагуу хог хаягдал хаяснаас орчинд бохирдол бий болох	Хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, шатаах, булаах, зөөвөрлөх явцад салхинд хийсэхээс сэргийлэх арга хэмжээ авах	
		Шинэ зам гаргах	Одоо байгаа замыг ашиглах; хэрэв салаа зам гаргасан тохиолдолд зогсоох, дарах	EMS
		Хаягдал чулуулгийн овоолго өөрөө элэгдэх, байгалийн хүчин зүйлээс хамааран элэгдэх	Хаягдал чулуулгийн овоолгыг холбогдох стандартын дагуу хийх	EMS
		Хаягдал чулуулгийн хяналтгүй овоолго	Ажлын графикийн дагуу хийж буйг хянах	EMS
		Цэвэр усны зумфанд тунаж буй усыг эргүүлэх ашиглах	Босоо малгалтын шүүрэлтийн усыг тунаах далаанд тунаж буйг хянаж байх	EMS
		Нөхөн сэргээлт удаан хугацааны турш хийгдэхгүй байх	Уурхайг ашиглаж дууссаны дараа зохих стандарт, шаардлагын дагуу хийх	БОНБНУ. III боть
		Ашигласны дараа элсний жижиг карьеруудыг нөхөн сэргээхгүй орших	Монгол улсын стандартын дагуу нөхөн сэргээлтийг хийх	EMS

Байгаль орчны бүрдэл хэсэг	Үйл ажиллагаа	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
Ус	Үйл ажиллагаа	Зөвшөөрөлгүй ухаж болзошгүй	Холбогдох хууль, дүрмийн дагуу зөвшөөрөл авах	EMS	
		БУЦБ	Цэвэрлэгдэж буй усны чанар муу байж болзошгүй	Цэвэрлэгдэж буй усны чанарт мониторинг хийх, хөрсөнд зайлуулж болох стандартын шаардлагын дагуу зөвшөөрөл авах	БУЦБ БОНБНУ
			Шаардлагатай хэсэгт нөхөн сэргээлт хийх	Барилгажилтын явцад хөндөгдсөн газрыг нөхөн сэргээх	БУЦБ БОНБНУ
	Машин, техник	Газар шорооны ажлаас болж газар, өнгөн хөрс эвдэгдэх	Зөвхөн батлагдсан, одоо ашиглаж байгаа замаар явах	БОНБНУ. III боть	
		Геологи хайгуул	Өрмийн зумпны шаррын уусмалтай ус хальж асгарах	Хамгаалалтын далан хийж өгөх	БОМС
	Шинээр тавигдсан замууд хуурай голын гольдрилыг боох		Голын гольдрил дээр зам тавихдаа ус чөлөөтэй урсах боломжийг хангасан суваг, туннель гаргаж өгөх	БОМС	
	Хуурай голын сайрт гаргасан нүхэнд ус шүүрэх, усыг ил гаргаж орхих		Голын сайр, гольдрилын дагууд хийгдэж буй геологи хайгуулын ажлын нөхөн сэргээлтийг ажлын гүйцэтгэлийн дараагаар нэн даруй хийж байх	БОМС	
	Далд уурхайн бэлтгэл ажил	Хаягдал чулуулгийн овоолгоос шүүрч гарах ус	Хаягдал чулуулгийн овоолгоос шүүрч гарах ус	Хаягдал чулуулгийн овоолгын шүүрлийг тусгай бэлтгэсэн зумпэнд хуримтлуулах	Shaft 1, 2 EIA
		Далд уурхайн бэлтгэл ажил	Хаягдал чулуулгийн овоолгын орчмын хөрс, ус хүчиллэг шинж чанартай болох	Хаягдал чулуулгийн овоолго болон тунаах зумпны суурь дэвсгэр нь үл нэвчүүлэх шинж чанартай материал буюу зохион байгуулалттайгаар хийгдсэн байх	Shaft 1, 2 EIA
			Усны нөөц хомсдох	Далд уурхайн шавхалтын болон аливаа газар шорооны ажлын шүүрлийн усыг аль болох дахин ашиглах технологи нэвтрүүлэх. Тух, шүүрлийн усыг тоосжилтыг бууруулахад ашиглаж болох ба ингэхдээ холбогдох стандартын шаардлагад нийцэж буй эсэхийг шалгасан байх шаардлагатай	Shaft 1, 2 EIA

Байгаль орчны бүрдэл хэсэг	Үйл ажиллагаа	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Баримтлах эрх зүйн баримт бичиг
		Шүүрэлгүй болон шавхалт хийсэн усны хэмжээг тогмол бүртгэж БО хэлтэст мэдээлж байх	Шүүрэлгүй болон шавхалт хийсэн усны хэмжээг тогмол бүртгэж БО хэлтэст мэдээлж байх	EMS
		Шавхалт болон шүүрлийн усны менежментийн талаархи үнэлгээний заалтуудыг баримтлах	Шавхалт болон шүүрлийн усны менежментийн талаархи үнэлгээний заалтуудыг баримтлах	EMS
	БУЦБ-ын байршил Ундай голын хуурай сайрт ойр байгаа тул цэвэршүүлэггүй бохир ус алдагдаж газрын доорхи усыг бохирдуулах эрсдэлтэй	БУЦБ-ын байршил Ундай голын хуурай сайрт ойр байгаа тул цэвэршүүлэггүй бохир ус алдагдаж газрын доорхи усыг бохирдуулах эрсдэлтэй	БО хэлтсийн заавар зөвлөмжийн дагуу хамгаалалтын далан байгуулж, аливаа гэнэтийн асгаралтын үед цэвэршүүлэггүй бохир ус алдагдахаас сэргийлж ажиллах	БУЦБ БОНБНУ
	Цэвэршүүлэггүй бохир ус алдагдах, ялангуяа бохирын шугам хоолой бөглөрөх, зэврэх, цооролт үүсэх	Цэвэршүүлэггүй бохир ус алдагдах, ялангуяа бохирын шугам хоолой бөглөрөх, зэврэх, цооролт үүсэх	Бохирын шугам хоолой дахь эвдрэл үүсэх эрсдэлтэй цэгүүдэд системийн хэвийн байдал тухайлбал бохир усны урсгал, даралт зэргийг хэмжих хэрэгсэл суурилуулж өгөх	БУЦБ БОНБНУ
	Цэвэршүүлэггүй бохир ус ихээр асгарч орчныг бохирдуулах, БУЦБ-д аваар осол тохиолдох	Цэвэршүүлэггүй бохир ус ихээр асгарч орчныг бохирдуулах, БУЦБ-д аваар осол тохиолдох	Хэрэв асгаралтын цар хүрээ бага бол зохих журмын дагуу ариутгал саармагжуулалтын ажлыг зохион байгуулж нөхөн сэргээх	БУЦБ БОНБНУ
	БУЦБ		Хэрэв асгаралтын цар хүрээ их бол орон нутгийн холбогдох албан тушаалтан, мэргэжилтэнд мэдэгдэж зөрчлийг арилгах талаар хамтран ажиллах	БУЦБ БОНБНУ
		Цэвэршүүлсэн усны чанар стандартын шаардлага хангахгүй байх	БУЦБ-аас цэвэршүүлсэн гарч буй усны чанарт байнгын хяналт тавих, хэрэв цэвэршүүлсэн усны чанар стандартын шаардлагыг хангахгүй байвал чанарыг сайжиртал цэвэршүүлсэн усны дахин ашиглалтыг түр зогсоож байх	EMS
			Лагийн бөөгнөрлийн үед хүчилтөрөгчөөр хангах, цистерн дэхь pH-г хэвийн түвшинд барих, азот нэмэх, илүүдэл лагийг зайлуулах үйл ажиллагааны давтамжийг ихэсгэх зэрэг арга хэмжээ авах	БУЦБ БОНБНУ
			Цистерн дэхь ууссан хүчилтөрөгчийг хэмжих, агааржуулалтын системийн найдвартай байдлыг хангах	БУЦБ БОНБНУ

Байгаль орчны бүрдэл хэсэг	Үйл ажиллагаа	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Баримтлах эрх зүйн баримт бичиг
			СН4; NH3; H2S; C2H6S зэрэг хийнүүдийн хэмжээг зохих түвшинд байгаа эсэхэд байнгын хяналт тавьж ажиллах	БУЦБ БОНБНУ
			Хаягдлын далан, болзошгүй түвшний бууралтын талбайд хяналтын цооногуудыг гаргаж гүний усны нөөц ба чанарын хяналтын ажлыг хэрэгжүүлэх	БОНБНУ. III боть
			Машин механизм болон бусад тоног төхөөрөмжийн угаалгын газарт зориулалтын ус тунгаагуурын системийг барьж байгуулах, хаягдал уснаас техникийн тосыг ялгах боломжтой байх шаардлагатай	EMS
			Ус ашиглалтын талбай дахь малчдын хугдийг тогтмол хянаж, усны түвшиний хэлбэлзэлийг бүртгэх	БОНБНУ. III боть
			Усны мониторингийн хяналтын хуудсуудаас дээж авч улиралд нэг удаа химийн бүрэн шинжилгээ хийлгэх	БОНБНУ. III боть
	Бусад	Газрын доорхи усны нөөц ба чанарт сөргөөр нөлөөлөх аливаа үйлдэл	Асгаралтыг хуримтлуулах тосгуур, байгууламжууд дахь хаягдал усыг хур бороо орсоны дараа суллаж байх. Шаардлагатай тохиолдолд усыг цэвэршүүлэх буюу саармагжуулж байж зохих газарт хаяна	EMS
			Голын гольдрилын зохицуулалт, өөрчлөлтийг хийхдээ Ундай голыг бохирдохоос сэргийлэх	БОНБНУ. III боть
			Ундай голын гольдрилын өөрчлөх төлөвлөгөөг тусгайлан боловсруулж, хэрэгжүүлнэ	БОНБНУ. III боть
			Ундай голын гольдрил өөрчлөх цэгээс доод ба дээд хэсэг дэхь задгай уст цэгүүд, хуудгуудын нөөц ба чанарын хяналтын төлөвлөгөө зохиож, хэрэгжүүлнэ	БОНБНУ. III боть

Байгаль орчны бүрдэл хэсэг	Үйл ажиллагаа	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ургамал			Гүний усны талаархи жилийн тайланг холбогдох агентлагт бэлтгэж өгөх, ус ашиглах гэрээ, хэлэлцээрийн дагуу холбогдох төлбөрийг төлөх	БОНБНУ. III боть
		Усны нөөцийн хомсдол	Усны жилийн тайланг нутгийн иргэд ба орон нутгийн захиргаанд танилцуулах, гэдний санал хүсэлтийг ажлын төлөвлөгөөнд тусгаж ажиллах	БОНБНУ. III боть
		Усны гольдрил, урсгын талбайн газрын гадаргын өөрчлөлт усны нөөц чанарт нөлөөлөх	Усыг ямар ч тохиолдолд хэмнэлттэй ашиглаж, үр ашиггүй зарцуулахаас сэргийлэх	EMS
		Гагнуурын рентген хальс боловруулалтын хаягдал усыг асгах	Усны гольдрилыг хааж боогдуулахаас сэргийлэх, орчны гидрологийг аль болох бага өөрчлөлтөд оруулах	EMS
		Усны эх үүсвэр, худгууд болон ус хангамжийн төв пэгүүдэд усны бохирдолт үүсэх	Аюултай хаягдлын ангилалд орох бөгөөд хадгалах, устгалд оруулах тусгай төлөвлөгөө боловсруулна	EMS
		Усны эх үүсвэрүүдийг хангаж буй худгуудийн усны нөөц шавхагдах	Усны чанарын хяналтын хөтөлбөр боловсруулан ажиллах, онцгой байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө зохиох	EMS
	Далд уурхайн бэлтгэл	Ховор, нэн ховор ургамлууд устгах, үйл ажиллагаанд өртөх	Ус авч ашиглаж буй цооногуудад усны тоолуур тавих	EMS
	Дайрганы уурхай	Өнгөн хөрсний овоолго хийх талбай нь нөлөөлөлд өртөх	Ховор ургамлын менежмент боловсруулж ажиллах, тухайлбал нүүлгэн шилжүүлэлт, үрийн нөөц бүрдүүлэх гэх мэт.	БОНБНУ. III боть
	Бусад	Усны нөөцийн хомсдол	Өнгөн хөрсний овоолго хийж байсан талбайн нөхөн сэргээлтийг бас стандартын дагуу хийх шаардлагатай	Дайрганы үйлдвэрлэлийн БОНБНУ
			Гүний усны болзошгүй түвшний бууралтын талбай дахь малчдын худаг, хайлаас модод зэргийг хянах	БОНБНУ. III боть
		Гүний хоолойн төв хэсгийн заган ойн мониторинг хийх	БОНБНУ. III боть	

Амьтан	БУЦБ	Хэрвээ сайн боловсруулашгүйгээр ил задгай хаявал лаг нь исэлдэн улмаар эвгүй үнэр гаргах, лаг дотор агуулагдаж байсан эмгэг төрүүлэгч бактери зэргээр орчны хөрс бохирдох	Лайгйг битүү саванд хийн хаягдлын цэгт аваачин газарт булах, ингэхдээ MNS 4288-95 стандартад заасан дагуу 0.5 метрийн гүнд хөрсөөр булах	БУЦБ БОНБНУ	
		БУЦБ-ийн механик шүүлтүүрээс гарах хатуу хог хаягдал нь аюултай буюу эмгэг төрүүлэгч бичил биетэн агуулсан байх	Лайгйг хаяхын өмнө эмгэг төрүүлэгч бактери байгаа эсэхийг шалгаж байх	БУЦБ БОНБНУ	
Амьтан	Бусад	Оюу Толгой орчимд хүн амын нягтрал ихсэхтэй холбоотой хулгайн ан гэх мэт сөрөг нөлөөлөл нэмэгдэх	Аюултай хог хаягдлыг устгах журам боловсруулж ажиллах	EMS	
		Усны нөөцийн хомсдол	Ан амьтны тухай, агнуурын тухай Монгол улсын хуулийг төслийн ажилчдад сурталчилан таниулах	БОНБНУ. III боть	
Нутгийн иргэд	Хогийн цэг	Органик хог хаягдал тухайн нутгийн ан амьтдыг хоолны хордлогод хүргэх. Жишээлбэл шувууд, үнэг гэх мэт.	Зэрлэг амьтдын ундаалдаг уст пэгүүдийг нөлөөлд өртөхөөс аль болох сэргийлэх, хэрэв зайлшгүй устгагдах бол тохиромжтой газарт өөр задгай ус гаргаж өгөх	БОНБНУ. III боть	
	Геологи хайгуул	Нутгийн иргэд, мал амьтан зумпны нүхэнд унаж осолдох	Хогийн цэгт хаяж буй хоолны үлдэгдэл, органик хог хаягдлыг ил задгай хаяхаас зайлсхийх	EMS	
	Дайрганы уурхай	Дуу чимээний хэмжээ хэт их байх нь ойролцоох нутгийн иргэдэд сөргөөр нөлөөлөх	Зориулалтын хашилт, хамгаалалтыг өрмийн зумп болон бусад хайгуулын үйл ажиллагааны улмаас үүссэн нүхийг тойруулж хийх	БОНБНУ. III боть	
	Нисэх зурвас	Нисэх зурвас	Онгоцны нислэг болон тэсэлгээний үед дуу чимээ, доргио чичиргээний хэмжээ стандарт хэмжээнээс их байх	Ойролцоо орших малчдын суурингуудад дуу чимээний хэмжилт хийж, үр дүнд үндэслэн нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөнө	EMS
				Төслийн ойр орчмын нутаг дэвсгэрт дуу чимээ, доргио чичиргээний хяналтын хөтөлбөртэй ажиллана	Нисэх буудлын БОНБНУ

7. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Оюу Толгой төслийг хэрэгжүүлэх явцад хийгдсэн БОНБНҮ-ий тайлангууд, БОХТ-д тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас үүдэн гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, давтамж хуваариудыг нэгтгэсэн ОХШХ-ийг боловсруулан 3-р хүснэгтэд үзүүлэв.

Төслийг хэрэгжүүлэхэд баримтлан ажиллах ОХШХ нь тус төсөл хэрэгжих орчны байгалийн болон нийгэм эдийн засгийн үнэт зүйлсийг хамгаалах, түүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг ямар үр дүнтэй байгааг илтгэх үндсэн баримт бичгийн нэг юм.

Төслийн уурхай болон баяжуулах үйлдвэр, түүний үйлчилгээний байгууламжуудыг барьж байгуулах, төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад хяналт шинжилгээний ажлыг энд тусгасан хугацаа болон аргачлалын дагуу үргэлжлүүлэн хийх нь тухайн төслөөс байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг шуурхай тогтоохоос гадна түүний олон жилийн судалгааны мэдээ материал нь говь нутгийн хөрс, ургамал, гадаргын ба газрын доорх ус зэрэг экосистемийн бүрдэл хэсгүүдийн хоорондын харилцан шүтэлцээг тодорхойлж, тэдгээрийн талаарх шинжлэх ухааны мэдлэгт тус нэмэр бий болгох чухал хэрэглэгдэхүүн болно.

Жил бүр хийгдсэн хяналт, шинжилгээний үзүүлэлтүүдийг анхааралтай судалж үзэж байх нь цаашдаа байгаль хамгаалах төлөвлөгөөг улам боловсронгуй болгох, байгаль орчин болон тухайн нутагт оршин суугчдыг төслийн нөлөөллөөс хамгаалах арга хэмжээг илүү үндэслэлтэй болгох юм. Нөгөө талаас ОХШХ-г улам боловсронгуй болгосноор хяналт, шинжилгээ хийж байгаа объектоо бүрэн хамарч буй эсэхийг хянахад чухал ач холбогдолтой байх болно.

Оюу Толгой төслийн байгаль орчныг хамгаалах 2009 оны төлөвлөгөөний хүрээнд боловсруулсан Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр заавал хийх ёстой гэж заасан боловч хяналт явуулж эхлэх хугацаа нь болоогүй буюу тухайн төслийг хэрэгжүүлж эхлэх үед хийх ёстой гэж заасан зарим үзүүлэлтүүдийг нэмж оруулж өглөө. Учир нь тэдгээр хэмжилт, хяналт шинжилгээг тухайн холбогдох төслийн үйл ажиллагаа явагдаж эхлэхээс өмнө хийж эхлэсэнээр орчны суурь нөхцлийн талаар олон жилийн мэдээлэлтэй болох, сүүлд нь төслийн зүгээс үзүүлж буй нөлөөллийг бодит байдал дээр үнэлж, дүгнэхэд үнэтэй баримт, судлагдахуун болох болно гэж үзсэн юм.

Хүснэгт 5. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Агаарын чанар	Талбай	Мониторингийн үзүүлэлтүүд		Байршил	Давтамж		
		Уур амьсгал	температур, салхины хурд, чиглэл, чийгшил, нарны цацраг, хур тунадас, цасан бүрхэвч				
Агаарын чанар	Уурхайн талбайд	Тосжилт	TSP; PM10; PM2.5;	Уурхайн талбайд Доорх хяналтын 5 цэг дээр: 1. N647596; E4767983; 2. N657245; E4763349; 3. N655696; E4758786; 4. N647169; E4757121; 5. N644554; E4777622;	өмнөхийг үргэлжлүүлэх долоо хоногийн 2, 5 дахь өдрүүдэд, нэг цэг дээр 24 цагийн хэмжилт хийх сард 1 удаа		
			Тоосны уналт				
			TSP			Уурхайн орчимд, бутлуурын цехийн ойролцоо, онгоцны буудлын ойролцоо	сар бүр
			хийн найрлага			Уурхайн ойролцоо, бутлуурын цехийн ойролцоо	сар бүр
			Бохирдол			TSP, SO2, NOx, CO, O3, Pь	Дулааны бойлороос гарах цэгэн эх үүсвэр дээр
Хөрс	Уурхайн талбайд		үгнэр	цэвэрлэх байгууламж	долоо хоногт		
			хөрсний төлөв байдал, хөрсний үе давхаргын зузаан (cm), элэгдэл эдрэлийн нөхцөл, ялзмаг %, рН; давсжилт; чийгшилт; Pь, As, сд, Hg, Cu-ийн агууламж	Доорх 5 хяналтын цэг дээр: 1. N648165; E4767018; 2. N654026; E4768014; 3. N653612; E4767380; 4. N655629; E4759845; 5. N647516; E4759617; Барилгын кемпийн орчимд болон DPS	жилд		
		рН, нийт азот болон нийт фосфор; 1 см ² дэх бактери; эмтэг төрүүлэгч бактери байгаа эсэх		Лагийн хаягдал цэг; барилгын кемпийн орчимд	жилд		

Усан хангамж, ус дамжуулах хоолойн дагуу	Цийгшилт	Булан Сухайт (Галбын говь); Ундайн сайрын зүүн дэнж; Галбын говийн зүүн хойд хэсэг; Гүн усны худаг, Талын Бор овоо; Алаг Баян уулын урд хөндий, Амтгайн тойрмын баруун хэсэг	жилд 2 удаа (хавар, намар)
Ус дамжуулах хоолойн дагуу	Температур	Ус дамжуулах хоолойн дагуух хяналтын 1 цэг дээр	долоо хоногт 2 удаа
Уурхайн талбайд	ургамлын төрөл зүйл, бүрхэц %, хяналтын талбай дахь төрөл, зүйлийн болон болгалиудын тоо, ургамлын дундаж өндөр см, газрын гадаргуугаас дээшхи ургамлын биомасс, кг/га	Лицензийн талбайн гадна орших хяналтын 7 цэгт: 1. N645504; E4767520; 2. N653934; E4769743; 3. N657081; E4763465; 4. N655963; E4758955; 5. N644691; E4760131; 6. N647910; E4769772; 7. N658510; E4756723;	жил тутам
	нутгийн ургамлыг тарималжуулах, үрийг нь цуглуулах г.м нөхөн сэргээлтийн ажил хийх	хашааны зүүн хойд өнцөгт, Говь оффис болон эргээж булсан зумлын талбайд	жил тутам
Усан хангамж, ус татах хоолойн дагуу	ургамалжилтын нягтшил, хяналтын талбай дахь зүйлийн тоо, биомасс	Ундай голын тагам, баруун зүүн дэнж; Булан Сухай; Дайчингийн заг; Хонгорын овоо; Гүний хоолойн төв хэсгийн хөндий; Алаг баян; Амтгайн баруун хөндий; Бор овооны талд	жил тутам
	Хайлаас, Сухай зэрэг модны болгалийн тоо	Ундай гол, Булан Сухай; Дайчингийн заг; Гүний хоолойн төв хөндий; Алаг Баян; Амтгайн баруун хөндий; Арцавчир худаг орчмын хайлаасуудын тоо, Хэмгийн худгийн орчим дахь Сухайн орвог;	жил тутам
	Бэлчээрийн ургамлын гарц	Гүний хоолой дахь 10-аас багагүй малчин өрхөөс санал асуулгын хуудас бөглүүлэх	жил тутам

Ургамалжилт

<p>Усан хангамж, ус татах хоолойн дагуу</p>	<p>Усан хангамж, ус татах хоолойн дагуу</p>	гадаргын ус	Нуур тойрмын мандлын талбай км ² , дундаж гүн, м.	Баг модны задгай, Булан Сухайтын тойром, Бутын Улаан нуур, Баянгийн нуур г.м түр орших нууруудаас 4 дөрвөн нуурыг Галбын говь, Гүний хоолойд сонгож	улирал бүр		
		Гар худаг	Булгийн урсгалын урт, өргөн, м; ундарга л/с	Их булаг; Ухаа загийн гол	улирал бүр		
			Гүний хоолой - усны түвшинг хэмжих	Гүн усны; Харцав; Хэмгий; Сэвхүүд; Бага мод; ерөлийн Амгтайн; Баятын; Үүдийн худаг зэрэг нийт 60+5 худагаас (5 гар худаг нэмэгдэж байгаа)	сар бүр		
		Цооног	Гүний хоолой - усны түвшинг хэмжих	Нийт 24 ажиглалтын цооногийн 48 цэг дээр	сар бүр		
		Уурхайн талбайд	Уурхайн талбайд	усны чанар	TDS, pH, хатуулаг (CaCO ₃); Са, Mg, Na, K, SO ₄ , NO ₂ , NO ₃ , NH ₄ , As, Cd, Cu; Hg, Pb, Zn, Cr, Fe, Ni; амт, үнэр, өнгө	Усны нөөц бүхий газрууд болон түвшний бууралтын урьдчилан таамаглаж буй газрууд дахь худгуудад	улирал бүр
				гадаад орчны дуу чимээ		Уурхайн хилээс 2 км зайд	
				тэсэлгээний чимээ, цуурай		тэсэлгээ хийгдэж байгаа байршлын ойр орчмын барилга байгууламж болон бусад шаардлагатай газар	эхний тэсэлгээний үед хэмжих цаашид шаардлагатай үеүүдэд хэмжих
				газрын чичрэлт		тэсэлгээ хийгдэж байгаа байршлын ойр орчмын барилга байгууламж болон бусад шаардлагатай газар	
		Геохими	Уурхайн талбайд	ажлын байрны дуу чимээ		хэмжих шаардлагатай ажлын байран дээр	
				Хаягдал чулуулгийн овоолго болон хаягдал хадгалах байгууламжид явагдах геохимийн процессийг хүчиллэг чулуулгийн урсцыг хянан, зохицуулах хөгөлбөрийн дагуу хянаж, баталгаажуулах		Хаягдал чулуулгийн овоолго, хаягдал хадгалах байгууламж, карьер, бага агуулгатай хүдрийн овоолгуудад	Хүчиллэг чулуулгийн урсцыг хянаж, зохицуулах хөгөлбөрг тусгасны дагуу болон үйл ажиллагаанаас хамаарч сонголтгоор

8. БАЙГАЛИЙН НӨӨЦ БАЯЛАГ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР

БОХ төлөвлөгөө болон Монгол улсын холбогдох хууль, журмын дагуу энэ онд аж ахуйн нэгжийн газар ашиглалтын төлбөрийг гэрээний дагуу, хайрга, дайрга, элс, орон нутгийн зам ашигласны төлбөрийг орон нутгийн захиргаатай гүйцэтгэлээр улирал тутамд тооцох болно.

Оюу Толгой дахь унд ахуй болон үйлдвэрлэлийн зориулалтаар авч ашиглах усны төлбөрийг сар тутамд тоолуурын заалтыг үндэслэн төлөх болно.

2009 онд байгаль орчныг хамгаалах арга хэмжэний зардал болон орон нутгийн төсөвт байгалийн нөөц баялаг ашигласны төлбөрийн хэлбэрээр оруулах хөрөнгийг урьдчилсан байдлаар төлөвлөж доор үзүүлэв.

Хүснэгт 6. 2009 онд байгаль орчныг хамгаалах арга хэмжээ болон зардал

№	Байгаль орчныг хамгаалах ажлууд	Тоо хэмжээ	Зардал /төг-өөр/
1.	Нөхөн сэргээлтийн ажил		
	Өрмийн зумп булах	1020 м ³ /жил	780 000
	Суваг, шуудуу дарах, техникийн нөхөн сэргээлт	10 000 м ³ /жил	3 895 000
2.	Хог хаягдлыг зайлуулах, цэвэрлэх		1 125 000
3.	Хайгуулын ангийн орчимд, зам дагуу, уурхайн хэсэгт усалгаа хийх	36 390 м ³ /жил	1 500 000
4.	Усны нөөцийг хамгаалах		400 000
5.	Биологийн нөхөн сэргээлт хийх туршилт		2 300 000
6.	Хяналт шалгалтууд		
6.1	Байгаль орчны дотоодын хяналт, шалгалтууд	7 хоног, сар тутам	
6.2	Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн хяналт		Улиралд 1 удаа
7.	Хойд Хюго хэсэгт нэвтрэх босоо малталтын хөндлөн нэвтрэлт Шүүрэлтийн усыг тунгаах далан		Тухайн төслийн зардалд тооцоолсон
8.	Чулууны ил уурхай, бутлах, бетон цех - Гоосжилтыг дарах усалгаа хийх		
9.	Элс авах талбай (гүний усыг ил гаргахгүй)		
10.	Мониторинг		Графикийн дагуу хийгдэнэ
10.1	Усны		
10.2	Хөрс ургамлын		
10.3	Агаарын чанарын		
Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд			10 000 000

11.		Байгаль орчны төлбөр хураамж		
	11.1	Ус ашигласны: - ахуйн (30 төг/м ³)	<i>Гэрээнд:</i> 56 736 м ³ /жил	Ус ашиглах гэрээний 10.2-т заасны дагуу чөлөөлөгдсөн. 6 134 400
		- үйлдвэрлэлийн (50 төг/м ³)	122688 м ³ /жил	
	11.2	- хайрга ашигласны (50 төг/м ³) - элс ашигласны (100 төг/м ³) - дайрга ашигласны (100 төг/м ³)	гүйцэтгэлээр	
	11.3	Үйлчилгээний зориулалтаар газар ашигласны	53.04 га	2 652 000
		Үйлдвэрлэл уурхайн зориулалтаар газар ашигласны	2455.6 га	245 560 000
	11.4	Орон нутгийн зам ашигласны	170 км х 7500 ₮	1 275 000
		Орон нутагт төлөх байгаль орчны төлбөр хураамжууд		255 621 400

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийн тайлант хугацаа

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан байгаль хамгаалах арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн байдалд АММИ ХХК-ийн байгаль орчны ажилтнууд тогтмол хялалт тавьж ажиллах бөгөөд 7 хоног тутамд болон сар бүр дотоод журмын дагуу тайла бэлдэж хэрэгжилтийн байдлыг үнэлүүлэх юм.

Түүнчлэн байгаль орчинд сөргөөр нөлөөлсөн аливаа зөрчил, буруутай үйлдэл, стандартын шаардлагаас доогуур нөхцөл байдал бүгдийг нь бүртгэх жагсаалт хөтлөж байх бөгөөд энэ нь тухайн зөрчлийг арилгах арга хэмжээ, хугацаа, хариуцах эзэн зэргийг тодорхойлж өгсөн чухал баримт бичиг болно. Хэрэв тухайн хэрэг зөрчил нь хамрах цар хүрээ, нөлөөлөх байдлын зэргээрээ байгаль орчин, хүний эрүүл мэндэд ноцтой хохирол учруулахуйц байгаа тохиолдолд аймаг, сум, орон нутгийн холбогдох мэргэжлийн байгууллага, эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэж сөрөг нөлөөллийг бууруулах тал дээр хамтран ажиллах болно.

Ашигт малтмалын тухай хуулийн дагуу Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт, орчны нөхөн сэргээлтийн ажлын биелэлтийн байдалд сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, аймгийн байгаль орчны албаар хянуулсаны үндсэн дээр холбогдох тайланг Монгол улсын Байгаль Орчны Яаманд хүргүүлэх юм.